



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР НИЙЦЛИЙН АУДИТЫН АЛБА



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2019 ОНЫ
ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ”-Д ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: НАГ-2020/05/-НА

Чойбалсан хот 2020 он



Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер В.Цэнгэлмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Батжаргал
Утас: 7058-4207, Цахим хаяг: batjargalb@audit.gov.mn
Аудитор М.Ухаанбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn



Товчилсон үгийн тайлбар.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4

**БҮЛЭГ 1 ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ЭХ ҮҮСВЭР ДЭХ ХАНДИВ
ТУСЛАМЖИЙН ОРЛОГЫГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.....5-6**

1.1 Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр дэх хандив тусламжийн орлогыг бодитой төлөвлөөгүй байна.....	5-6
---	-----

**БҮЛЭГ 2 ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЖУРАМД ЗААСАН
БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЗОРИЛГОД НИЙЦҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ
БАЙНА.....7-10**

2.1 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөхдөө холбогдох хууль, журамд заасан ажлуудыг бүрэн хийхгүй байгаа нь гүйцэтгэлд нөлөөлж байна.....	7-8
--	-----

2.2 ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтад анхаарах асуудал байна.....	8-10
--	------

**БҮЛЭГ 3 ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ, АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТИЙН ЯВЦАД ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛААГҮЙ
БАЙНА.....10-12**

3.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн явцад хяналт тавьж ажиллаагүй байна.....	11-12
--	-------

3.2 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж хүргүүлсэн ч олон нийтэд мэдээлэх ажил хангалтгүй байна.....	12-13
---	-------

3.3 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмж хэрэгжилт 93.5 хувьтай байна.	13
---	----

ДҮГНЭЛТ:.....	13
---------------	----

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:.....	14
------------------------------------	----

ЗӨВЛӨМЖ:.....	15
---------------	----

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:.....	16-18
-------------------------------------	-------



Товчилсон үгийн тайлбар

НА	Нийцлийн аудит
НАГ	Нийцлийн аудитын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ДОА	Дорнод аймаг
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
МУЕА	Монгол Улсын ерөнхий аудитор
СС	Сангийн сайд
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ХБТХ	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ОНО	Олон нийтийн оролцоотой
ШГБ	Шууд гэрээ байгуулах
ШХА	Шууд худалдан авалт
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
БОЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв



**Аудит хийх
үндэслэл, бүрэн
эрх**

Аудитын зорилт

**Аудитын хамарсан
хүрээ**

**Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт**

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх
мэдэгдэл**

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2019 оны А/100 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын тайланг ҮАГ-т хүргүүлж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийсэн. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээг журмын дагуу төлөвлөж, зарцуулсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх;

Аудитад аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2019 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналыг аймаг, сумдын ИТХ, ЗДТГ, СТСХ, ХБТХ, Баг, хороодын Засаг дарга, ИНХ-ыг хамруулан шалгасан.

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 3000, АДБОУС 4000 дугаар стандартууд, Төрийн аудитын тулгуур зарчим MNS6817:2020, Нийцлийн аудитын зарчим MNS6817-6:2020, МУЕА-ын 2016 оны А/146 тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын түр журам”-ыг баримтлан, аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтэс, албаны мэргэжилтэнтэй ярилцах, иргэдээс санал асуулга авах, судалгаа авч дүн шинжилгээ хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөөг тайлантай тулган баталгаажуулах арга зүйг ашигласан.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер В.Цэнгэлмаа хэрэгжүүлж, нийцлийн аудитын албаны ахлах аудитор Б.Батжаргал, аудитор М.Ухаанбилэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын талбарын ажлыг 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлүүлж, тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ҮАГ-ын Нийцлийн аудитын газар болон аймгийн Засаг даргад 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр хүргүүлээ.



I Бүлэг. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр дэх хандив тусламжийн орлогыг бодитой төлөвлөөгүй байна.

1.2. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр дэх хандив тусламжийн орлогыг бодитой төлөвлөөгүй байна.


Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуулиар ОНХНС-гаас Дорнод аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 6104.7 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-аар орон нутгийн хөгжлийн сангийн төсвийг ОНХНС-гаас 6104.7 сая төгрөг, гадаад дотоодын хандив тусламжаас 4253.5 сая төгрөг нийт 10358.2 сая төгрөгийн санхүүжилтээр бүрдүүлэхээр баталсан байна.

Төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулахад ОНХНС-гаас санхүүжих орлого 96.3 хувь, дотоод гадаадын хандив тусламжаас орох орлого 73.3% хувьтай төвлөрсөн байна.

ОНХС-гийн эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг графикаар харуулбал:

График 1



Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих орлого 3.7 хувь буюу 228.3 сая төгрөгөөр тасарсан нь сангийн яамнаас санхүүжилтийг бүрэн олгоогүйтэй, хандив тусламжийн орлого 26.7 хувь буюу 1135.1 сая төгрөгөөр тасарсан нь орлогын тооцоо, судалгааг хангалттай хийлгүйгээр төлөвлөсөнтэй холбоотой байна. Энэ нь батлагдсан төсвийн гүйцэтгэлийг бууруулж байна.

Төсвийн тухай хуулийн 59.2-т “Аймаг, нийслэл нь Орон нутгийн хөгжлийн сангаас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд хуваарилна” гэж заалтын хэрэгжилтийг үзэхэд аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс сумдад олгох хуваарилалтыг хийгээгүй, харин Сангийн яамнаас хийж ирүүлсэн байна.

Сангийн яам ОНХНС-гаас аймагт шилжүүлсэн орлогын шилжүүлгийг аймаг, сумдын ОНХС-нд дараах байдлаар хуваарилсан байна.



Хүснэгт 1

Сангийн ямаас хуваарилалт	Мөнгөн дүн /сая.төг/
ОНХС-гаас аймгийн ОНХС-д хуваарилагдсан нийт санхүүжилт	6104.6
Суурь зарлага	500.0
Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 50 хувь	534.2
Тогтвортой амжиргаа-3 төслийн эх үүсвэр	764.2
Итгэлцүүрээр хуваарилах дүн	4306.2
Сумдын ОНХС-д хуваарилах суурь дүн /30%/	1291.8

Аймгийн ОНХС-гаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн талаар Төсвийн тухай хуулийн 59.2.2-т “энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 30-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах” гэж заасны дагуу аймгийн ОНХС-нд 70 хувь, сумдын ОНХС-нд 30 хувийг хуваарилсан байна.

Хүснэгт 2 Сумдад олгосон хуваарилалт

Сумын ОНХС-нд итгэлцүүрээр хуваарилсан суурь дүн /сая.төг/					
д/д	Сумын нэр	Алслалтаас хамаарах хуваарилалт 30%	Хүн амын тооноос хамаарах хуваарилалт 40%	Нутаг дэвсгэрээс хамаарах хуваарилалт 30%	Итгэлцүүрээр хуваарилах суурь дүн
1	Баяндун	45.3	20.10	19.6	85.00
2	Баянтүмэн	2.6	15.50	26.1	44.20
3	Баян-Уул	65.1	30.30	17.6	113.00
4	Булган	7.7	12.10	22.3	42.10
5	Гурванзагал	14.1	9.20	16.5	39.80
6	Дашбалбар	45.2	20.90	27.3	93.40
7	Матад	28.9	17.00	71.6	117.50
8	Сэргэлэн	10.1	12.80	13.1	36.00
9	Халхгол	76.3	19.80	88.1	184.20
10	Хөлөнбуйр	17.2	11.80	11.8	40.80
11	Хэрлэн	0	294.80	0.9	295.70
12	Цагаан-Овоо	31.4	23.10	20.4	74.90
13	Чойбалсан	11	17.70	31.8	60.50
14	Чулуунхороот	32.6	11.60	20.5	64.70
	Сумдын дүн	387.5	516.7	387.6	1291.8

Статистикийн мэдээллийн нэгдсэн сангаас аргачлалд заасан сумдын хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, алслалт гэсэн үзүүлэлтүүдийг авч сумдад хуваарилах дүнг дахин тооцоолж үзэхэд зөрүү гараагүй.



II Бүлэг. Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг журамд заасан бүс нутгийн хөгжлийг дэмжих зорилгод нийцүүлэх шаардлагатай байна.

2.1 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөхдөө холбогдох хууль, журамд заасан ажлуудыг бүрэн хийхгүй байгаа нь гүйцэтгэлд нөлөөлж байна.

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар ОНХС-ийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн баталсан. Уг журам нь 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөс мөрдөгдөж эхэлсэн тул 2019 оны ОНХС-ийн төлөвлөлтөд иргэдээс санал авах үйл ажиллагаанд өмнө мөрдөгдөж байсан журмыг баримтлан ажилласан байна.

Аудитад аймгийн болон 14 сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны үйл ажиллагааны барим материалыг бүрэн хамруулж, хийгдсэн ажлуудыг газар дээр нь үзэхдээ өмнөх онуудын хяналт шалгалтад хамрагдсан байдал, эрсдэл зэргийг харгалзан үзэж 9 сумыг түүвэрт хамруулсан.

Өмнөх аудитаар ОНХС-гаар хэрэгжүүлэх ажлын саналыг иргэдээс бодитоор авсан эсэх нь бүрэн нотлогдохгүй, санал авсан анхан шатны баримт шаардлага хангахгүй зөрчил илэрч байсан.

Аудитын түүвэрт хамрагдсан 9 суманд санал авахдаа холбогдох журамд заасан ажилбаруудыг бүрэн хийсэн эсэхийг үзэхдээ саналыг бусад анхан шатны баримтуудтай тулгах, санамсаргүй түүврээр иргэдтэй холбогдож лавлах зэрэг горимуудыг хэрэгжүүлсэн. Хөлөнбуйр, Булган, Баяндун, Дашбалбар, Чойбалсан, Хэрлэн сумдад зөрчил илрээгүй бөгөөд Баяндун, Халхгол, Гурванзагал сумд саналын хуудаснуудыг нэг хүний гараар бөглөсөн, санал өгснөөр баримтжуулсан, иргэн уг саналыг өгөөгүй байх зэрэг өмнөх аудитын зөрчлүүд давтан гарсан.

Орон нутгийн хөгжлийн сангийн шинэчилсэн журмын 3.1.4 “ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад сум, дүүргийн төвөөс алслагдсан баг, хорооны иргэдийн хамгийн олон саналыг авч эрэмбэлэгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг заавал багтаах;” гэж заасан байна.

Түүвэрт хамрагдсан сумдаас Халхгол, Чойбалсан сумд нь дээрх заалтыг зөрчин алслагдсан багийн иргэдийн хамгийн олон саналыг авч эрэмбэлэгдсэн, хууль, журмын шаардлагад нийцсэн төсөл, арга хэмжээг сумын ОНХС-ийн хэрэгжүүлэх ажлын жагсаалтад оруулаагүй байгааг цаашид анхаарч ажиллах нь зүйтэй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд иргэдээс батлагдсан маягтаар нээлттэй санал асуулгыг авах ажил тодорхой хэмжээгээр хэвшиж байгаа боловч орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөх, саналыг тооцоо судалгааны үндсэн дээр хууль, журмын шаардлагад нийцүүлэн эрэмбэлэх ажил бүрэн хийгдэхгүй байна. Төсөл арга хэмжээг эрэмбэлсэн гэж байгаа ч энэ нь нийтлэг байдлаар зөвхөн саналын тоог харуулсан жагсаалт төдий байна.



Аймаг, сумдын ОНХС-гийн ажлын хэсгүүд нь саналыг журамд заасан үзүүлэлтүүдийн дагуу үнэлж, орон нутгийн бодлого, чиглэлтэй уялдуулсан, төслийн төсөвт өртгийг үр өгөөж хүртэгчдийн тоонд харьцуулсан дүн шинжилгээ хийн, дүгнэлт, зөвлөмж гаргаж ажиллаагүй байна.

Мөн СС-ын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан журмын 3.1.7 “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн ажлын хэсэг нь тус сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргах,” гэсэн заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Сумдад хуульд нийцээгүй, санал аваагүй арга хэмжээг эрэмбийн жагсаалтад оруулсан, эрэмбийн жагсаалтад байхгүй ажлыг ИТХ-д оруулж батлуулдаг зөрчлүүд гарсаар байна. Тухайлбал:

- Баяндун сум: Эрэмбийн нэгдсэн жагсаалтад байхгүй гандангийн засвар тохижилтын ажилд 8,0 сая төгрөг,
- Дашбалбар сум: Иргэдийн санал аваагүй цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажилд 10,0 сая төгрөг,
- Хэрлэн сум: Эрэмбийн нэгдсэн жагсаалтад байхгүй, БОЭТ-ын хүүхдийн тасгийн засварын ажилд 20.0 сая төгрөг, Хан-Уул цогцолбор сургуульд чанга яригчийн аппарат худалдан авах 5.0 сая төгрөг, ОНХС-гаар хэрэгжүүлж болох чиг үүрэгт хамаарахгүй С.И.Грицевецийн хөшөө байгуулах ажилд 10.0 сая төгрөг,
- Халхгол сум: Эрэмбийн жагсаалтад байсан ажлыг өөрчилж музейн шалны өнгөлгөө хийж, гэрэлтүүлгийг сайжруулах ажилд 23.0 сая төгрөг, ОНХС-гаар хэрэгжүүлж болох чиг үүрэгт хамаарахгүй Ялалтын 80 жилийн ойд 53,2 сая төгрөг, овооны тахилгад 5,0 сая, улсын олимпиадад 10,0 сая төгрөг, дэд хөтөлбөрүүдэд 10,7 сая төгрөг,
- Чойбалсан сум: Эрэмбийн нэгдсэн жагсаалтад байхгүй цэцэрлэгийн барилгын засварын ажилд 34.0 сая төгрөг,
- Гурванзагал сум: Эрэмбийн нэгдсэн жагсаалтад байхгүй халуун усны барилгыг засварлах ажилд 5.0 сая төгрөгийг тус тус төлөвлөсөн байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсэгт “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно:”, 60.3.3. “үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал;”, 60.3.6 “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.” , ОНХС-гийн үйл ажиллагааны журмын 3.1.2. дахь заалтад “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх,” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Энэ нь тус сангийн үндсэн зорилго болох хөгжлийг дэмжих, иргэдийн тогтвортой амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг санхүүжүүлж чадахгүй байх нөхцөл байдлыг бий болгож байна.

2.2. ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтад анхаарах асуудал байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд өмнөх оноос шилжүүлсэн 15, шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 286 буюу нийт 301 төсөл, арга хэмжээг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу зохион байгуулсан байна.



Өмнөх оноос шилжсэн	Тайлант оны ажил	Нийт ажил	Худалдан авах ажиллагааны журам			ШХА	ОНО
			Төндөр шалгаруулалтын онцгой журам				
			НТШ-ын журам	Харьцуулалтын арга	ШГБ		
15	286	301	29	107	119	28	3

Үүнд: Нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 10.1 хувь буюу 29, харьцуулалтын аргаар 37.4 хувь буюу 107, шууд гэрээ байгуулах аргаар 41.6 хувь буюу 119, олон нийтийн оролцооны аргаар 1.0 хувь буюу 3, шууд худалдан авалтаар 9.8 хувь буюу 28 ажлын худалдан авалтыг зохион байгуулсан байна.

- Сумдад худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тендерийн баримт бичгийг Сангийн сайдын 2015 оны 169 дүгээр тушаалаар шинэчлэгдэн батлагдсан “Тендерийн үнэлгээний заавар маягтууд”-д заасан үзүүлэлтүүдийн дагуу үнэлээгүй байгаа бөгөөд хурлын тэмдэглэлээр үнэлж сонгон шалгаруулсан байна.

Аудитаар ОНХС-гаар хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлтэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Хэрлэн сум: “Орон сууцны гаднах орчныг камержуулах” 15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлаар орон сууцны 3, 4, 7, 8-р байруудад байршуулсан камер ажиллахгүй, байруудын гаднах орчныг харах хянах боломжгүй байна.
- Баян-Уул сум: Сумын төвийн айл өрхүүдийн дунд 8 сая төгрөгөөр “гүн өрмийн 4 худаг” гаргасныг ашиглагчтай гэрээ байгуулж хариуцлагыг баталгаажуулаагүй байна.
- Халхгол: Малчдын дунд 10.0 сая төгрөгөөр “гүн өрмийн худаг” гаргасан ч ашиглагчдад хүлээлгэн өгөөгүй байна.
- Гурванзагал сум: Сумын хог тээврийн автомашиныг 6.0 сая төгрөгөөр засварласан гэх боловч хэвийн үйл ажиллагаанд ороогүй, айлын хашаанд эвдэрсэн байдалтай байна.
- Дашбалбар сум: Иргэд чөлөөт цагаа өнгөрөөх боломжгүй сумын төвөөс хол байршилд “цэцэрлэгт хүрээлэн байгуулах” 10,0 сая төгрөгийг зарцуулсан нь ногоон байгууламжгүй, гэрэлтүүлэггүй, морины хөшөө бүхий хашаа төдий байна.
- Аймаг: Дашбалбар суманд “Сумын төвөөс Чух нуурын чиглэлд ЦДАШ барих ажилд дэмжлэг” 70,0 сая төгрөгийг ажлыг гэрээний хугацаанаас 30 хоногоор хоцроож гүйцэтгэсэн байхад 1.0 сая төгрөгийн алданги тооцолгүйгээр үлдэгдэл санхүүжилтийг олгосон байна.
- Аймаг: Гурванзагал сумын цэцэрлэг өргөтгөлийн 100.0 сая төгрөгийн барилга нь үндсэн цэцэрлэгтэйгээ холбогдоогүй, хана таазны будаг, шохой унасан, шал зай завсартай хөөж овойсон, дулаан алдалт ихтэй чанаргүй хийгдсэн байна.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1. “Захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авах талаар дараах эрх, үүрэгтэй байна: “ 46.1.4 “худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах”, 46.1.6 “бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.



ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг санхүүгийн бүртгэл тайланд тусгахгүй орхигдуулдаг зөрчил өмнөх онуудтай харьцуулахад буурсан байгаа ч аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр Баян-Уул суманд баригдсан 38.0 сая төгрөгийн өртөг бүхий хүүхдийн цэцэрлэгийн салбар бүлгийн барилгыг өмчлөгчийг тодорхой бусаас шалтгаалж бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь цэцэрлэгийн барилга орон нутгийн төсвөөр баригдсан ч байршил нь Хилийн цэргийн 275 дугаар ангийн эзэмшлийн газарт байгаатай холбоотой байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт,...”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

III Бүлэг. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн явцад хяналт тавьж ажиллаагүй байна.

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн явцад хяналт тавьж ажиллаагүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлд Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” 9.4 -т заасны дагуу төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавьж ажиллахаар зохицуулсан.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба

Баяндун, Баянтүмэн, Баян-Уул, Булган, Гурванзагал, Дашбалбар, Сэргэлэн, Цагаан-Овоо, Матад сумдын ОНХС-гийн 2019 оны хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажилласан байна.

Бусад сумд болон аймгийн ОНХС-гийн 2019 оны хөрөнгийн зарцуулалтад хяналт шалгалтын ажлыг 2020 ондоо багтаан гүйцэтгэхээр төлөвлөсөн нь хийгдэж байна.

Сумдын орон нутгийн хөгжлийн санд хийсэн дотоод аудит нь ОНХС-гийн зарцуулалт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаанд түлхүү чиглэгдсэн байна. Цаашид ОНХС-гийн төлөвлөлтийн үйл ажиллагаанд анхаарах шаардлагатай байна.

Аймаг, сумын ИТХ-ын дэргэдэх хороо

Аймаг, сумдын ИТХ нь ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих хороог байгуулж ажилласан байна.



Хяналт тавьсан эсэх байдлыг дараах хүснэгтээр харуулав.

д/д	Нэрс	ИТХ-ын дэргэд Хяналтын хороо байгуулсан эсэх	Хяналт тавьж ажилласан эсэх
1	Баяндун	тийм	үгүй
2	Баян-Уул	тийм	тийм
3	Булган	тийм	тийм
4	Гурванзагал	тийм	тийм
5	Дашбалбар	тийм	тийм
6	Халхгол	тийм	тийм
7	Хөлөнбуйр	тийм	тийм
8	Хэрлэн	тийм	тийм
9	Чойбалсан	тийм	тийм
	Аймаг	тийм	үгүй

Аймгийн болон Баяндун сумын ИТХ-ын дэргэдэх хорооноос хяналт тавьсан эсэх нь баримтаар нотлогдохгүй байна. Бусад сумдын хувьд хөрөнгө оруулалтын ажлуудын явц болон гүйцэтгэлийг газар дээр нь очиж үнэлж дүгнэсэн байна.

3.2. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж хүргүүлсэн ч олон нийтэд мэдээлэх ажил хангалтгүй байна.

Сумдын ЗДТГ нь ОНХС-гийн үйл ажиллагааны журмын 9.2-т заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлж ажилласан байна.

Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-гийн үйл ажиллагааны журмын 9.3 дахь “Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум, дүүрэг тус бүрээр хагас жил тутамд гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулна.” гэсэн заалтын дагуу ОНХС-гийн хэрэгжилтийн тайланг гаргасан байна.

Харин тайлангийн талаарх дүгнэлт, саналыг Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэр гаргуулах тухай заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ОНХС-гийн үйл ажиллагааны журмын 9.5-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Журам шинэчлэн батлах тухай” 89 дүгээр тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн



захиргааны байгууллагууд хийнэ.”, 9.6-д “Энэ журмын 9.5-д заасны дагуу хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг ОНХС-ийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тухай бүр мэдээлэх үүргийг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар хүлээнэ.” гэж заасан.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.5, 9.6-д заасны дагуу хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн тайлан, дүгнэлт, зөвлөмжийг ОНХС-ийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлээгүй байна.

3.3 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмж хэрэгжилт 93.5 хувьтай байна.

Төрийн аудитын газраас өмнөх онд ОНХС-гийн үйл ажиллагаанд УАГ-ын нэгдсэн удирдамж, дарга бөгөөд тэргүүлэх аудиторын баталсан дэд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэсэн.

Уг аудитаар ОНХС-гийн хөрөнгийг хуульд нийцэхгүй арга хэмжээнд төлөвлөн зарцуулсан, иргэдийн саналыг аваагүй, санхүүжүүлсэн төслүүдийн үр дүн хангалтгүй, сумдад ОНХС-д тавих хяналт хангалтгүй байгаа зэрэг алдаа, зөрчлүүдийг илрүүлж, 123.5 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоон, 351.7 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага, 27.9 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 1 санал, 160.3 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгч холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн.

- Төлбөрийн актаас Хөлөнбуйр суманд тавигдсан 44.3 сая төгрөгийн актаас 15.9 сая төгрөг үлдэж, бусад актууд бүрэн барагдаж биелэлт 87 хувьтай байна.
- Албан шаардлага, зөвлөмжийн биелэлт 100 хувьтай байна.

Өмнөх аудитаар илэрсэн зөрчлийн төрлүүд аймгийн хэмжээнд дүгнэхэд давтагдаж байгаа хэдий ч тухайн сумын хувьд давтан гаргаагүй байна.

3.4 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хүрээнд нийтийн эзэмшлийн хөрөнгө нэмэгдэж, гудамж талбайн тохижилт сайжирсан байна.

Аймаг, сумдад 2014-2019 онуудад ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг нийтлэг байдлаар нь төрөлжүүлж авч үзвэл:

- Аймаг, сумдын тохижилт, нийтийн эзэмшлийг сайжруулах чиглэлээр гудамж талбайн гэрэлтүүлэг, камержуулалд, хог тээврийн автомашин, явган зам, хүүхдийн тоглоомын талбай байгуулах,
- мал, амьтны халдварт, шимэгчлэх өвчинтэй тэмцэх, гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр мал угааврын банн, мал тарилгын хашаа хийх, гал түймэр унтраах багаж хэрэгсэл худалдан авах,
- сумын нутаг дэвсгэрийн бэлчээрийн менежмент хийх чиглэлээр хөдөөгийн багуудад гүн өрмийн худаг гаргах,



- хот төлөвлөлт, барилгажуулалт, шинээр дэд бүтэц бий болгох чиглэлээр цахилгаан дамжуулах агаарын шугам татах, авто зам тавих ажлууд нийтлэг хийгдсэн байна.

Эдгээр төсөл, арга хэмжээний үр дүнд иргэдийн эрүүл, аюулгүй амьдрахад чиглэгдсэн нийтийн эзэмшлийн тохижилт, бэлчээрийг усжуулах асуудлууд тодорхой хэмжээнд шийдвэрлэгдэж үр дүн гарсан байна.

Харин орон нутгийн иргэдэд өмнөх онуудын сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний хэрэгжилт болон дараагийн төсвийн жилийн аймаг сумдын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг танилцуулах ажил хангалтгүй байна.

Энэ нь иргэдийн өөрсдийн тулгамдаж буй асуудлын ач холбогдол, нийтийн ашиг сонирхолд нийцэх байдлыг үнэлэхэд нөлөөлж байна.

Цаашид ОНХС-гийн үйл ажиллагааны талаарх иргэдийн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлж, оролцоог бүс нутгийн хөгжлийг дэмжихэд чиглүүлэхэд анхаарах нь зүйтэй байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр дэх хандив тусламжийн орлогыг бодитой төлөвлөөгүй байна.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг журамд заасан бүс нутгийн хөгжлийг дэмжих зорилгод нийцүүлэх шаардлагатай байна.
3. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөхдөө холбогдох хууль, журамд заасан ажлуудыг бүрэн хийхгүй байгаа нь гүйцэтгэлд нөлөөлж байна.
4. ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтад анхаарах асуудал байна.
5. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн явцад хяналт тавьж ажиллаагүй байна.
6. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж хүргүүлсэн ч олон нийтэд мэдээлэх ажил хангалтгүй байна.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

21000, Чойбалсан, Дорнод аймаг
Утас: 7058-4202, факс: 7058-4584

2020.11.12 № 1/2189
танай 2020.11.10-ны № 756 -т

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ
ТАНАА

Аймгийн “Орон нутгийн хөгжлийн сангийн
2019 оны хөрөнгийн зарцуулалт”-д хийсэн нийцлийн
аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитын дүн дүгнэлтийн дагуу тайланг сумын
Засаг дарга нарт хүргүүлж, зөвлөмжийг
хэрэгжүүлэн, актын биелэлтийг 2021 оны 04 дүгээр
сарын 30-ны дотор хүргүүлж ажиллах болно.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ  Ч.ГАНБАТ

010620705



ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараах албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын даргад:

1. Аймгийн ОНХС-д хандив тусламжийн орлогын эх үүсвэр тодорхойгүй, албан ёсны гэрээ хэлэлцээгүйгээр тусгасан орлогыг ИТХ-аар батлахгүй байх.

Аймгийн Засаг даргад:

1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг сайжруулахад анхаарч ажиллах.
2. Орон нутгийн хөгжлийн санд хийсэн аудитын тайланг сумдын Засаг дарга нарт хүргүүлэх.

Сумдын Засаг дарга нарт:

1. Орон нутгийн иргэдийн саналыг нэгтгэж эрэмбэлэхдээ ОНХС-гийн үйл ажиллагааны журмын 6.4-т заасан ажлуудыг бүрэн хийж байх.
2. ОНХС-гий хөрөнгийг хууль, журамд заасны дагуу зарцуулж, олон нийтэд мэдээлж ажиллах.

Аудитаар нийт 1507.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлэн 6.0 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоон, зөрчил арилгуулах 223.9 сая төгрөгийн 5 албан шаардлага, 1277.1 сая төгрөгийн 4 зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитаар тавигдсан төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангуулж 2021 оны 05 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ:



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2020 оны 11 сарын 12 өдөр

Дугаар 29

Чойбалсан хот

Нийцлийн аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29.2, 29.4 дэх заалт, Нийцлийн аудитын түр журам"-ын 9.2 дахь заалт, Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар тавигдсан төлбөрийн актыг нэгдүгээр хавсралтаар, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор С.Энхбаатар, аймгийн ИТХ-ын дарга М.Энхтөр, аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн нарт тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор /Б.Батжаргал/-д даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

110419127



Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын 2020 оны
11 дүгээр сарын 12-ны өдрийн
29 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Төлбөрийн актын жагсаалт

№	Байгууллагын нэр	Төлбөрийн актын дугаар	Төлбөрийн актын дүн /сая.төг/
1	Халхгол сумын Засаг дарга	01/83	5.0
2	Аймгийн Засаг дарга	02/84	1.0



Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын 2020 оны
11 дүгээр сарын 12-ны өдрийн
№2 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Албан шаардлагын жагсаалт

№	Байгууллагын нэр	Албан шаардлагын дугаар	Албан шаардлагын дүн /сая.төг/
1	Баян-Уул сумын Засаг дарга	01/177	46.0
2	Хэрлэн сумын Засаг дарга	02/178	50.0
3	Халхгол сумын Засаг дарга	03/179	106.9
4	Дашбалбар сумын Засаг дарга	04/180	10.0
5	Гурванзагал сумын Засаг дарга	05/181	11.0



ДОРНОД АЙМАГ, ХЭРЛЭН СУМ, 7-Р БАГ АЙМГИЙН ЗДТГ-ЫН 2 ДУГААР БАЙР
УТАС: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207
И-МЭЙЛ: DORNOD@AUDIT.GOV.MN , ВЕБ САЙТ: WWW.AUDIT.MN